



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/606

Баруун-Урт сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Баруун-Урт сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй М.Алтанзул захиралтай “Дүүрэн бадрах” ХХК-ийн “Дүүрэн бадрах” хүнсний дэлгүүр, Асгат сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Чулуунжав захиралтай “Дөхөмийн хүр” ХХК-ийн “Цэцэг” хүнсний дэлгүүр, Эрдэнэцагаан сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Саруулжаргал захиралтай “Мөнх ариун суурьт” ХХК-ийн “Оргил” хүнсний дэлгүүр, Баяндэлгэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Ж.Содномцэрэн захиралтай “Ширээт мөнх” ХХК-ийн “Содон” зоогийн газар, Наран сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Д.Эрдэнэбаатар захиралтай “Бударчандмань” ХХК-ийн “Чандмань” Баруун-Урт сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй З.Рэгзэдмаа захиралтай “Далай хамар” ХХК-ийн “Ану” хүнсний дэлгүүр, Эрдэнэцагаан сумын 8 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Болортуяа захиралтай “Гэгээн арвижих” ХХК-ийн “Nice” зоогийн газрын согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай сунгаж, Баяндэлгэр сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Б.Алимаа захиралтай “Жигүүр хүлэг ХХК-ийн “Тамир-2” хүнсний дэлгүүрт спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай олгосугай.

2222011214

2.Тусгай зөвшөөрөл сунгагдсан болон шинээр олгогдсон аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Гантулга), Мэргэжлийн хяналтын газар (С.Нямжав), Стандарт хэмжил зүйн хэлтэс (Д.Эрдэнэбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллахыг дээрх аж ахуй нэгжүүдийн захирлуудад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  М.ИДЭРБАТ